



ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 01 сарын 28 өдөр

№ 01

Дархан уул аймаг

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх
тухай асуудлаарх санал хураалтын дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.3, “Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комисс компанийн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хэлэлцсэн санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн санал:

1. Саналын хуудас 12ш-г тарааж, хайрцаг задлахад 12ш саналын хуудас гарав.
2. Саналын хуудас хүчинтэй 12ш, хүчингүй 0-ш байв.
3. Санал хураалтын дүнгээр:

Зөвшөөрсөн -	1786	санал	100	хувь
татгалзсан -	0	санал	0	хувь
түтгэлзсэн -	0	санал	0	хувь

-ийн санал авсан тул нийт хуралд оролцсон сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар “зөвшөөрсөн” дүнтэй батлуулах санал оруулсугай.

Тооллогын комиссын дарга *Т. Энхцэцэг*

Гишүүд *М. Отгон* Ж.Отгон





ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2026 оны 01 сарын 28 өдөр

№ 02

Дархан уул аймаг

Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай
санал хураалтын дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.3, “Тээвэр дархан” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комисс компанийн их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцсэн санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнгээр:

Зөвшөөрсөн - 1786 санал 100 хувь

татгалзсан - 0 санал 0 хувь

түтгэлзсэн - 0 санал 0 хувь

-ийн санал авсан тул компанийн их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгохыг “зөвшөөрсөн” дүнтэй батлуулах санал оруулсугай.

Тооллогын комиссын дарга

Г.Энхцэцэг

Гишүүд

Ж.Отгон





ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2026 оны 01 сарын 28 өдөр

№ 03

Дархан уул аймаг

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
ирцийг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, “Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшигчдийн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит бус хуралд оролцогчдод мандат олгосон бүртгэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Тээвэр дархан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит бус хуралд оролцохоор хүрэлцэн ирсэн нийт 157938 ширхэг хувьцааг эзэмшигч буюу 15 хувьцаа эзэмшигч оролцохоор мандат олгосон бүртгэлээр ирцийг тогтоосугай.

Тооллогын комиссын дарга *Г. Энхцэцэг* Г. Энхцэцэг

Гишүүд *Ж. Отгон* Ж. Отгон





ТЭЭВЭР ДАРХАН

“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 01 сарын 28 өдөр

№ 04.

Дархан уул аймаг

Сонирхлын зөрчилтэй, их хэмжээний хэлцэл хийх
зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 61.1.5 дахь заалт, 61.4. дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.3 дахь хэсэг, “Тээвэр Дархан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ын 3.6 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 08 дугаар тогтоол, “Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит бус хурлын тэмдэглэл, Тооллогын комиссын 02, 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тээвэр Дархан” ХК-ийн хараат буюу толгой компани болох “Монгол Алт” ХК-ийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Хаан банк” ХК-иас 10,000,000,000.0 (арван тэрбум) төгрөгийн барилгын зээл авах, компанийн өөрийн эзэмшлийн, улсын бүртгэлийн Y-2003020673, Y-2003020671, Y-2003020679, Y-2003020674, Y-2003020680, Э-2003002006 дугаар бүхий үл хөдлөх хөрөнгүүд болон газруудыг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэл хангуулах хэлбэрээр барьцаалуулах зөвшөөрөл олгож, холбогдох гэрээ хэлцэл байгуулах, барьцааны гэрээнд “Тээвэр Дархан” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (М.Оюун)-д олгосугай.

2. Дээрх сонирхлын зөрчилтэй буюу их хэмжээний хэлцэл нь хуулийн дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гарган танилцуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулахыг Аудитын хороо (Л.Амарсанаа), Ерөнхий нягтлан бодогч (Д.Бямбажаргал) нарт үүрэг болгосугай.



Ж.ОЧИРСҮХ